


“Патрикейн”ХХК

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИХ ТӨМӨР ЗАМЫН АЧИХ БУУЛГАХ ТАЛБАЙ ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



“Теем смайл” ХХК
Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг
4-р хороо, Ялалт плаза 903 тоот
Утас:99058080, 77113711
e-mail: teamsmile.lc@gmail.com

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.1 Төслийн нэр	2
1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	2
1.3 Төслийн хүчин чадал	2
1.4 Дэд бүтэц.....	3
1.5 Цахилгаан хангамж.....	3
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	4
2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил ,физик газарзүйн нөхцөл	4
2.2 Уур амьсгал.....	4
2.3 Ургамлан нөмрөг.....	5
2.4 Хөрсөн бүрхэвч	5
2.5 Төсөл хэрэгжих орон нутгийн нийгэм эдийн засгийн байдал.....	5
3.1 Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	7
3.2 Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл	7
3.3 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	8
3.4 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл	8
3.5 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл үргэжлэх хугацаа, эрчим.....	8
БҮЛЭГ 4. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	Error!
Bookmark not defined.	
4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах менежментийн төлөвлөгөө	8
4.2 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	18
4.3Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	18
4.4 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	19
4.5 Орчны болон барилгажилтын хог хаягдлын төлөвлөгөө	23
4.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	25
4.7 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	27
4.8 Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	32

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн нэр

“Төмөр замын ачилт буулгалтын талбай” байгуулах төсөл

1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл


Төсөл хэрэгжүүлэгч: “Патрикейн” ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 9011728141
Регистрийн дугаар: 5512778
Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар 1-р хороо, 4 давхар
Утас: 99999169, 99085676

1.3 Төслийн хүчин чадал

Төмөр замын ачилт буулгалтын талбай нь “УБТЗ” ХНН-ийн Чойр өртөөнөөс баруун тийш салбарласан Р50 маягийн, 1/9 маркийн суман шилжүүлгийн хамт 1741 м урт төмөр зам байгуулахаар төлөвлөсөн ба жилийн турш тасралтгүй үйл ажиллагаагаа явуулна.

‰ _____ - Á Á + _____ Á: _____ Á

- J Зориулалт- Чойр өртөөнөөс ачиж буулгах талбай хүртэлх холбох зам
- J Гар удирдлагатай
- J Ачилт буулгалтын 1-р зам 417.72м
- J Ачилт буулгалтын 2-р зам 387.33м
- J Татах 3-р зам 87.50м
- J Тахирын эхлэл ПК-0+37.31
- J Тахирын төгсгөл ПК 6+29.90
- J Хязгаарын шон 300м
- J Призмын ёроол 75м



Зураг № 1 Төсөл хэрэгжих талбайд байрлах салбар төмөр зам

А

- J Эзэмшлийн талбайг хүрээлсэн 2м өндөр төмөр торон хашаа
- J Талбайн гэрэлтүүлэг
- J Хяналтын камер

1.4 Дэд бүтэц

Тухайн төслийн хувьд ачилт буулгалтын талбай нь Чойр өртөөнөөс баруун тийш салбарласан Р50 маягийн, 1/9 маркийн 879.32м урт төмөр замаар бараа таваарыг ачиж, буулгах ба жилийн турш тасралтгүй үйл ажиллагаагаа явуулна.

А

А

К

- J Чойр өртөөнөөс салбарласан 1 салаа 879.32м, Р50 маягийн төмөр зам
- J Өндөр тавцан
- J Ачилт буулгалтын талбай
- J Авто болон вагон пүү
- J Пүүний ажлын байр
- J Ажилчдын амралтын байр зэрэг байрлана.



Зураг № 2 Төслийн талбайд байрлах объектууд

1.5 Цахилгаан хангамж


Цахилгаан эрчим хүчээ “УБТЗ” ХНН-ийн эрчим хүч ус хангамжийн 2-р ангитай гэрээ байгуулан эрчим хүчний шугамаас татсан байна.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил , физик газарзүйн нөхцөл

“Патрикейн” ХХК нь Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р багын нутаг дэвсгэрт Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн А/103 тоот шийдвэрийг үндэслэн нэгж талбарын 4201007067 дугаар бүхий 20 га, 000310307 газар эзэмших эрхийн гэрчилгээг үйлдвэрлэлийн зориулалтаар эзэмшдэг.

Төсөл хэрэгжих талбай нь Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р баг Аяган-100 тоот газарт, 20000 м.кв газар дээр төмөр замын ачих, буулгах талбайн зориулалтаар ашиглан байрлаж байна.



Зураг № 3 Төсөл хэрэгжих талбайн байршил

Далайн түвшнээс дээш 1000-1500 м өргөгдсөн. Физик газарзүйн хувьд тал хээрийн мужид, геоморфологийн хувьд говь, хээрийн бүсэд багтах бөгөөд улаан хүрэн шавранцар хөрстэй. Газар хөдлөлийн эрчим 7 балл. Сумын нутаг дэвсгэр нь уул, гүвээ толгод бүхий тал хээр, мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд тохиромжтой.

2.2 Уур амьсгал

Халуун нь +32 хэм хүртэл дулаарах хандлага тохиолддог. Жилдээ 200-250 мм хур тунадас унадаг нь Говийн бүсийн дунджаас илүү юм. Уур амьсгалын хувьд хуурайдуу сэрүүвтэр. өвлийн улиралд хамгийн хүйтэн нь -33 хэм, зуны улиралд Хонь, тэмээ, үхэр, ямаа, адууны аж ахуй эрхлэхэд нэн тохиромжтой. Хаврын өдрийн урт 10 цагаас бага, цэлмэг өдөр 7 өдрөөс бага, бүрхэг өдөр 5-аас бага, зуны өдрийн урт 10 цагаас бага, зуны бүрхэг өдөр 5-аас бага, цэлмэг өдөр 3-аас их, намрын өдрийн урт 8 цагаас бага, бүрхэг өдөр 3-аас бага, цэлмэг өдөр 13- аас бага, өвлийн өдрийн урт 7 цагаас бага, Өвөлд орох

цасны дундаж хэмжээ 10 см-ээс бага, цас тогтох хугацаа 11-р сарын 21 12-р сарын 1, цас арилах хугацаа 3-р сарын 15 хүртэл үргэлжилдэг. Салхины хамгийн их хурд 25 м/секунд. Салхины чиглэлийг авч үзвэл 1-р сарын Розагаар хойд, баруун хойд, зуун зугийн салхи голлодог. Салхигуй тохиолдол 22 хоног. Салхины дундаж хурд нь хойд зүгийн салхи 2-4 м/сек, баруун хойд зүгийн салхи 4-6 м/сек, баруун хойд зүгийн салхи 2-4 м/сек байдаг. 7-р сарын салхины розаг авч үзвэл салхигуй хоног 21, хойд зугийн салхи 18 м/сек, баруун хойд зугийн салхи 4-6 м/сек, зуун хойд зугийн салхи 2-4 м/сек, баруун урд зугийн салхи 2-4 м/сек байдаг. Аймгийн нутагт хүйтэвтэр хоногийг авч үзвэл хамгийн олон нь 122, хамгийн цөөн нь 95 хүйтэрдэггүй хоног 80-100 байдаг. Энэ нь байгаль цаг уурын хувьд гадаадын иргэд ажиллаж амьдрахад тохиромжтой нөхцөл юм.

2.3 Ургамлан нөмрөг

Нутгийн баруун хойд талаар хялгана, харгана, баруун өмнөд талаар бударгана дэрс, зэрэг голлосон тойрмын ургамал голлох бегеед бэлчээрийн евел хаврын даац нь дунджаар 08-1,0 центнер га, зун намрын даац нь 2,5-3,0 центнер га-гийн нөөцтэй тул 80,0 мянгаас илуу малыг бэлчээрээр ха нгах боломжгүй юм. Бэлчээрийн хувьд хялгана - харгант, хазаар өвс – хялгант, хиаг – хялгана – хазаар өвст соргог өвст бэлчээр бүхий хуурай хээр зонхилж, хялгана(говийн)- таана – баглуурт, хялгана – хазаар өвст – агьт, хялгана – боролзой – шарилжит, хялгана – харгана, таана – хялганат, таана – улалж, бударгана – шарилжит, дэрс – бударгант, бор шавагт, бударгана – хармагт цөлийн хээр зонхилдог байв. Хужиртай байдам (нуга шавартай) газарт таана- улалж, улалж – зурман сүүлт, ахар сорт арвай – марцны цэгээлж – ширэг зонхилно.

2.4 Хөрсөн бүрхэвч

Хөрс-газарзүйн мужлалтаар нутгийн хойт хэсэг нь Төв Азийн их мужийн Хангайн мужийн өргөрөгийн бүсийн хүрэн хөрсний бүсийн 2-р тойрог, нутгийн өмнөд хэсэг нь Говийн мужийн өргөрөгийн бүсшилийн цайвар хүрэн хөрсний дэд бүсийн 4-р тойрог, цөлөрхөг хээрийн бор хөрсний дэд бүсийн 6-р тойргуудад тус тус хамрагдана Хүрэн хөрс манай оронд хамгийн өргөн дэлгэр тархах бөгөөд газарзүйн байрлал гарал үүслийн хувьд нугат хээрийн хар шороон хөрснөөс цөл хээрийн бор хөрсөнд шилжих завсрын шинж чанартай юм. Монгол оронд тархсан хүрэн хөрсийг газарзүй гарал үүслийн онцлогоор нь тал хээрийн хүрэн хөрс, уулт хээрийн хүрэн хөрс, нугат хээрийн хүрэн хөрс гэж үндсэн 3 бүлэгт хувааж болно. Дээрх мужлалтаар авч үзэхэд тус аймгийн нутагт тал хөндийн болон нам уулс, ухаа гүвээ толгодын хүрэн, мараалаг хүрэн, нугат хүрэн, цайвар хүрэн, мараалаг говийн бор, хужир, марз, шал, мараа хөрс голлон тархах, хүрэн, цайвар хүрэн болон нугархаг хөрс өчүүхэн бага талбайг хамарна.

2.5 Төсөл хэрэгжих орон нутгийн нийгэм эдийн засгийн байдал

Говьсүмбэр аймаг нь засаг захиргааны нэгжийн хувьд Сүмбэр, Шивээговь, Баянтал, гэсэн 3 сум, 9 багтай. Хүн ам, өрхийн мэдээллийн нэгдсэн цахим санд Говьсүмбэр аймгийн харьяат 17.5 мянган хүн бүртгэлтэй байгаагаас 1.7 хувь нь гадаадад оршин сууж байна. Нийт хүн амын 98.3 хувь нь суурин хүн ам байна. Суурин хүн амын тоо өмнөх оноос 3.2 хувиар нэмэгджээ. Суурин хүн амын 73 хувь буюу 17.2 мянга нь аймгийн төвийн сум буюу Сүмбэр суманд, 5.3 хувь буюу 1.2 мянга нь хөдөөгийн сум болох Баянтал, Шивээговь сумдад 20.1 хувь нь амьдарч байна.

Говьсүмбэр аймагт 1969 оноос эхлэн каракуль хонийг өсгөн үржүүлж байна. Каракуль хонь нь хар, саарал, хүрэн зүстэй байдаг. Нутгийн монгол хониноос амьдын жин, ноос, мах, сүүний гарцаар илүү. Буржгар арьсны чиглэлийн каракулийн “Сүмбэр” үүлдрийн хонь нь биологийн ангиллаар ширүүн ноост, урт өөхөн сүүлт хонины үүлдэрт хамаарна. Харин ашиг шимээрээ хурганы арьс, сүүний чиглэлийн хонинд ордог. Каракуль хурганы арьс нь өвөрмөц хээтэй, маш гоёмсог буржгар, хөнгөн нимгэн хөрстэй,

үс нь торгомсог, уян хатан чанар сайтай олон янзын өнгөтэй байдгаараа дэлхийн зах зээлд нэрд гарсан эрэлт хэрэгцээ өндөртэй бүтээгдэхүүн юм. Чойр уулын зүүн тал Сүмбэр уулын эргэн тойронд 1:50000, төмөр замын дагуу 1:200000 масштабтай хийгдсэн гидрогеологийн судалгааны ажлын дүнд тоосгоны шавар, хүрэн нүүрс, газрын тос, холимог металл болон эрдэс будгийн нөөцийг тогтоосон байна. Ер нь аймийн төвөөс 100 километрийн радиус дотор 30 гаруй төрлийн ашигт малтмалын орд, илэрц байдаг: хайлуур жонш /38 сая тонн/, холимог металл /1.1 сая тонн/, төмрийн хүдэр /13 сая тонн/, бал чулуу /200 мянган тонн/, хүрэн нүүрс /13 биллион тонн/. Улсын хэмжээнд томд орох Шивээ-Овоогийн нүүрсний уурхайтай. Жилдээ 2 сая тонн нүүрс олборловол 300 жилийн нөөцтэй. Тус аймгийн нутаг дэвсгэр дээгүүр олон улсын темер зам болон агаарын зам дайран өнгөрдөг. Ачаа тээврийн, иргэний зорчигч тээвэрлэх бух төрлийн даацын онгоц хеерч буух 3 км урттай, 72 м-ийн ергентэй 2 зурвас бүхий онгоцны буудалтай. Монгол улсын хойд хилээс өмнөд хил хүртэл тавигдсан шилэн кабелийн шугамд холбогдсон. Тоон АТС-ын системд шилжсэн, хөдөлгөөнт холбоо суурилагдсан. Дэлхийн аль ч улс оронтой телефоноор болон интернетээр харилцах боломжтой. Налайх – Чойрын чиглэлийн 200 км хатуу хучилттай зам барилгын ажил 2002 оны 05 сард эхэлсэн ба 2004 оны 06 сард ашиглалтанд орох юм. Цахилгаан эрчим хүчний дамжуулах станц нь хүчин чадлынхаа 33 %-г ашиглаж байгаа нь цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэр нөөцтэй гэсэн үг. Аймгийн төвийн усанд агуулагдах төмрийн хэмжээг багасгасан нөхцөлд үйлдвэрлэлийн буюу ундны усны хангалттай нөөцтэй болно. Шивээ-Овоогийн уурхай одоогийн хэрэгжиж буй төслийн хүрээнд жилд 2,0 сая тн нүүрс олборлоход 100-аас доошгүй жил ашиглах нөөцтэй.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1 Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- J Ачаа бараа ачих болон буулгахад гарах тоос
- J Ачаа бараа тээвэрлэж ирэх автомашинаас ялгарах хорт хий
- J Галт тэрэгнээс ялгарах хорт хий болон дуу чимээ
- J Зам барилгын ажлын үед гарах тоос
- J Ачилт буулгалтын талбайд тээврийн хөдөлгөөнөөс гарах тоос зэрэг болно.

Автотээврийн хэрэгсэл болон бусад төхөөрөмжийн дуу чимээ болон хорт хий утаа гарах, тоос шороо дэгдэх зэргээр агаар орчныг бохирдуулж, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлнө. Үүнээс гадна барилга угсралтын үйл ажиллагаа болон тээврийн хөдөлгөөнтэй холбоотойгоор агаарын бохирдол үүсч болзошгүй. Төлөвлөж буй төслийн барилгын үйл ажиллагааны явцад тоосжилт, тухайн бүс нутгийн уур амьсгалын нөхцөлтэй уялдан их, бага хэмжээгээр үүсэх учраас энэ асуудлыг зайлшгүй авч үзнэ. Төсөл хэрэгжих орчны хуурай уур амьсгал, хүчтэй салхи шуурга зэрэг нь төслийг төлөвлөх болон хэрэгжүүлэх шатанд холбогдох зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүй бол ихээхэн хэмжээний тоосжилт орчиндоо бий болгох нөхцөлтэй.

3.2 Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөлийн эх үүсвэр нь төслийн талбайд баригдах барилга байгууламж, овоолго, ажилчдын тосгон, хүнд даацын машины хөдөлгөөн, антропогений хүчин зүйлс зэрэг юм.

- J Төмөр замын ачих буулгах талбайн төслийн 5 жилийн хугацаанд нийт 0.35 га талбай өөрчлөлтөнд орж хөрсөн бүрхэвч нөлөөлөлд өртөхөөр байна. Төслийн хүрээнд төлөвлөж буй барилга байгууламжид хөрс удаан хугацаанд дарагдана. Түүнчлэн дэд бүтцийн барилга, байгууламжийн ойр орчимд машин техник, хүний үйл ажиллагаагаар элэгдэл, эвдрэл, бохирдол үүснэ. Төслийн үйл ажиллагааны явцад машин техникийн эвдрэл гэмтэлээс үүдэн тос, тослох материалын асгаралт, шүүрэлтээс хөрс бохирдох боломжтой.
- J Техникийн хөдөлгөөнөөс хучилтгүй -зам талбайн хөрс элэгдэж, эвдрэх, ургамлан нөмрөг талхлагдах
- J Ачиж тээвэрлэх, буулгах явцад гарах тоос хөрсөн дээр хаягдсанаар хөрсний шинж чанар өөрчлөгдөх
- J Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаяагүй, мөн ангилан ялгаагүйгээс болж хөрсийг бохирдуулах
- J Ажилчдын ариун цэврийн газар болон хоолны газраас гарах шингэн хог хаягдлын байгууламж байхгүй, тэдгээрийн эвдрэл гэмтэл, дүүрэх зэрэг асуудлаас хөрс бохирдох
- J Ахуйн бохирын усыг шаардлагын хэмжээнд хүртэл цэвэрлэж шүүгээгүй тохиодолд шууд гадагшлуулж байгальд хаях нь хөрс бохирдуулах нэг эх үүсвэр болох талтай.
- J Антропогений хүчин зүйлээс үүдэн ажилчдын ариун цэврийн газар болон хоолны газраас гарах шингэн хаягдлын байгууламж байхгүй зэргээс үүдэн хөрс бохирдох нөлөөтэй. Гэхдээ MNS4943:2015-ын дагуу бохирын усыг цэвэрлэх системийг шаардлагын дагуу зөв барьж хэрэглэвэл зөвшөөрөгдөх хэмжээнээс бага бохир ус гарах боломжтой. Бохирын цэвэрлэгээний систем бий болсон нөхцөлд түүнээс гарах усны нөлөө бага байна.

3.3 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Ачиж, буулгах хөдөлгөөнөөр орчны ургамлан бүрхэвч талхлагдах, ажиллагсад зориудын бус замаар явах, анхаарал болгоомжгүйгээс гал түймэр гарах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс олон салаа зам үүсэх, дэд бүтцийн барилга байгууламж барих зэрэг нь ургамлан нөмрөгт нөлөөлөн, түүний төрөл зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах (хог ургамал ихсэх), зэрэг сөрөг нөлөөллүүд үүсч болзошгүй.

3.4 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төсөл хэрэгжих явцад байгалийн усны нөөц болон усны бохирдолд үзүүлэх нөлөөлөл нь төдийлэн эрчимтэй бус юм. Гэвч ахуйн бохир ус болон хог хаягдлыг зөв байршуулаагүй мөн орчны цэвэрлэгээ хийгээгүйн улмаас гадаргын болон газрын доорхи ус, хөрсний ус бохирдуулж болзошгүй.

3.5 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл үргэлжлэх хугацаа, эрчим

Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим: Уг төслийг хэрэгжүүлснээр байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, судалгаа хийсэн мэргэжлийн судлаачдын дүгнэлтүүдийг үндэслэн тогтоов. Байгаль орчны төлөв байдалд гарч болзошгүй нөлөөлөл, болзошгүй ослын үнэлгээг магадлан жагсаах аргаар тодорхойлов.

Магадлан жагсаах /checklist/ аргаар тооцсон нөлөөллийн үнэлгээ: Үнэлгээ хийгдэж буй төслийн үйл ажиллагаа байгаль орчны төлөв байдал, нийгэм эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмийг тодруулахын тулд магадлан жагсаах (checklist) аргыг ашиглав. Энэ арга нь нөлөөллийг байна (х), байхгүй (хоосон) гэсэн хэлбэрээр тодорхойлж шууд, шууд бус шинжтэй, удаан, богино хугацаагаар буцалтгүй болон буцаж нөлөөлөх, хүчтэй, дунд болон бага зэрэг эрчимтэй байх зэрэг үзүүлэлтүүдээр авч үзсэн болно.

Төслийн байгаль орчинд сөргөөр нөлөөлөх эх үүсвэрүүдэд дараах хүчин зүйлс орж байна. Үүнд:

- 🚧 Автотээврийн хэрэгслээс ялгарах хорт хий
- 🚧 Ачиж буулгах явцад үүсэх тоосжилт
- 🚧 Ачих, буулгах, тээвэрлэх үйл явц.


Төсөл хэрэгжсэнээр тухайн нутгийн байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй нөлөөллийг хүснэгт № 4-д харуулав.

№	Байгаль орчны үзүүлэлт	Нөлөөлөл					Хугацаа		Давтамж		Эрчим	
		Шууд	Шууд бус	Өөрөө	Богино хугацааны	Удаан хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Бага зэрэг	Дунд зэрэг	Хүчтэй	
Байгалийн экосистемийн өөрчлөлт												
1	Газрын доорх урсацын өөрчлөлт											
2	Гадаргын усны чанарын өөрчлөлт		х			х	х			х		
3	Ургамлан бүлгэмдлийн бүтцийн өөрчлөлт	х				х		х			х	
4	Хөрсний элэгдэл, эвдрэл	х				х		х			х	

“ПАТРИКЕЙН” ХХК

5	Геологийн тогтоцын өөрчлөлт	x				x		x		x	
6	Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт	x				x		x		x	
7	Уур амьсгалын өөрчлөлт		x			x		x		x	
Байгалийн нөөцийн ашиглалт											
8	Газрын доорх нөөц баялаг	x				x		x		x	
9	Бэлчээрийн байдал	x				x		x		x	
10	Эрдэс түүхий эдийн нөөц	x				x		x		x	
Байгаль орчны чанарын өөрчлөлт											
11	Агаарын бохирдол	x			x		x			x	
12	Ундны усны нөөц хомсдох		x			x		x	x		
13	Хөрсний бохирдол		x			x	x			x	
14	Дуу чимээ, шуугианы нөлөөлөл	x			x			x		x	
Нийгэмд үзүүлэх нөлөөлөл											
15	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөл	x				x		x	x		
16	Хүн амын орлого өөрчлөгдөн нэмэгдэх		x			x		x	x		
17	Хүн амын тоо өөрчлөгдөх		x			x		x	x		
Байгалийн цогцолборт газар, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентлогийн олдвор											
18	Байгалийн өнгө төрх өөрчлөгдөх	x				x		x			x
19	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x		x	
20	Тусгай хамгаалалттай ба цогцолборт газарт нөлөөлөл										
21	Түүх сёлын дурсгалт зүйлд нөлөөлөл										
22	Археологи, палентлогийн олдворт нөлөөлөл										
Эдийн засаг, байгаль орчин											
23	Орон нутгийн орлого нэмэгдэх		x			x		x		x	
24	Ажлын байр нэмэгдэх	x				x		x		x	
25	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		x		x			x	x		
Бусад нөлөөлөл											
26	Шороон зам, машин механизмын хөдөлгөөн, тээвэрлэлтээс хөрс эвдрэх	x				x	x				x
27	Ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс ба усыг бохирдуулах	x				x	x			x	
28	Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	x			x		x			x	
29	Хүчтэй салхи, уруйн үер	x			x		x			x	
Дүн		18	8		5	20	7	18	5	15	6

Дээрх хүснэгтээс харахад тус төслийн үйл ажиллагааны явцаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл өөр хоорондоо харилцан уялдаа холбоотой нэг нь нөгөөдөө шууд буюу дам байдлаар нөлөөлөх нь харагдаж байна.




Тус төслийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөллийг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрд үзүүлэх ба 7.1% нь “бага”, 45.2% нь “дунд”, 42.8% нь “их”, 4.8% нь “маш их” гэсэн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамаарагдаж байна. Нөлөөлөлд өртөж буй байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдээс агаар орчин нөлөөлөлд илүүтэйгээр өртөхөөр байна.




БҮЛЭГ 4. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах менежментийн төлөвлөгөө

Хүснэгт №. 1 Сөрөг нөлөөллийг бууруулах менежментийн төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөлийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамаарах хүрээ	Хэрэгжүүлэх хувь	Тайлбар	Зураг
АГААРЫН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ					
<p>Галт тэрэгний зүтгүүрийн хаягдал утаа агаар орчныг бохирдуулах Төслийн талбайд ахуйн хог хаягдлын сав, бохир ус дамжуулах хоолой болон бохир ус цуглуулах хэсгийн битүүмжлэл муу байснаас үнэрийн бохирдол үүсэх</p>	<p>Зүтгүүр болон засвар үйлчилгээний механизмуудын дизель хөдөлгүүрүүдэд үе шаттайгаар утаан дахь хортой бодисын хэмжээг багасгах катализаторуудыг тавих</p>	<p>Төслийн талбай</p>	<p>100</p>	<p>Утаан дахь бодисын хэмжээг багасгах зориулалтаар ачигч машинд суурьшуулсан.</p>	

“ПАТРИКЕЙН” ХХК



	<p>Салхины хурд, дуу чимээг бууруулах зорилгоор мод бут тарих</p>	<p>Үйл ажиллагааны турш</p>	<p>100</p>	<p>“Тэрбум мод” төслийн хүрээнд төслийн талбайд 8285 ширхэг мод тарьсан.</p>	 
	<p>Хог хаягдлыг битүү саванд хуримтлуулж тухай бүрт нь хогийн цэгт хаях, ариутгах, хогийн цэгийг хлорын шохойн 5-10%-ийн уусмалаар ариутгаж байх</p>	<p>Үйл ажиллагааны турш</p>	<p>100</p>	<p>Хлорын шохойн 5-10%-ийн уусмалаар ариутгасан.</p>	


“ПАТРИКЕЙН” ХХК



	<p>Тоосжилтыг бууруулах зорилгоор усны машин авч дотоод зам талбайг услах</p>	<p>Үйл ажиллагааны турш</p>	<p>100</p>	<p>Тоосжилтыг бууруулах зорилгоор усны машин авч дотоод зам талбайг усалж ажилласан.</p>	
	<p>Тоосжилт дарах усалгааны усыг Шивээ Овоогийн нүүрсний уурхайгаас татах гэрээ байгуулах</p>	<p>Үйл ажиллагааны турш</p>	<p>100</p>	<p>Тоосжилт дарах усыг орон нутгийн зөвлөснөөр ойролцоох гүний худаг болон борооны усыг хуримтлуулан хангаж байна.</p>	<p>Тоосжилт дарах усыг орон нутгийн зөвлөснөөр ойролцоох гүний худаг болон борооны усыг хуримтлуулан хангаж байна.</p>

	<p>Төмөр замын ачих буулгах талбайн тоосжилтыг бууруулахын тулд нарийн ширхэгт тоосонцорыг шүүж авч үлдэх жижиг сүв бүхий металл хавтангаар хийгдсэн хашааг барьж агаарыг чөлөөтэй нэтрүүлэх тул салхи шуурганд тэсвэртэй тусгай хашааг барих</p>	<p>Үйл ажиллагааны турш</p>	<p>100</p>	<p>Металл хавтангаар хийгдсэн хашааг барьж агаарыг чөлөөтэй нэтрүүлэх тул салхи шуурганд тэсвэртэй тусгай хашааг барьсан.</p>	
<p>ХӨРСӨН ОРЧИН БОЛОН УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</p>					
<p>Төмөр зам тавих барилгын ажлын үе шат, автомашины хөдөлгөөн зэргээс хөрс элэгдэл, эвдрэл үүсэхээс гадна хог хаягдал, бохирын шингэн алдагдсанаас хөрсөнд бохирдол үүсч болзошгүй.</p>	<p>Автомашины зогсоол, дотоод зам талбайг тэмдэгжүүлэх</p>	<p>Төслийн талбайн зам талбай</p>	<p>100</p>	<p>Автомашины зогсоол, дотоод зам талбайг тэмдэгжүүлсэн.</p>	

“ПАТРИКЕЙН” ХХК

	Төслийн объектууд хооронд явган хүний зам тавих (өнгөт хавтан, чулуу, хөндий банзан г.м)	Төслийн талбайн зам талбай	100	Төслийн талбайн гадна орчим зам талбайг 2022оны 5-р сард бетондож эхэлсэн.. Энэхүү төслийн ажил нь үе шаттайгаар хэрэгжинэ.	
	Стандартын шаардлага хангасан бохир усны цооног, бие засах газар бий болгох	Төслийн талбай	100	Бохир усны цооног, бие засах газар бий болгосон.	

	<p>Тоосжилтыг багасгах зорилгоор дотоод зам дээр хайрга дэвсэх</p>	<p>Төслийн талбайн зам талбай</p>	<p>100</p>	<p>Тоосжилтыг багасгах зорилгоор дотоод зам дээр хайрга дэвссэн. / Дэвсэж буй үеийн зураг /</p>	
<p>АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</p>					
<p>Төслийн үйл ажиллагаанаас бий болох хог хаягдлыг эмх замбараагүй хаяснаар амьтдын амьдрах орчин бохирдох, зарим зүйл амьтан хордох</p>	<p>Хог хаягдлыг түр цуглуулах цэг бий болгох Төслийн талбайн ойр орчмын хог хаягдлыг тогтмол цэвэрлэх</p>	<p>Төслийн талбай</p>	<p>100</p>	<p>Хог хаягдлыг түр цуглуулах цэг бий болгосон.</p>	

	Хил хязгаарын дагуу хашаажуулах	Төслийн талбай	100	Төслийн талбайд бетон блокоор хашаажуулсан..	 
ДУУ ЧИМЭЭНИЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ					
Нутгийн иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулах	Ачих буулгах ажлыг өдрийн цагаар гүйцэтгэх	Үйл ажиллагааны явцад	100	Манай компани нь хөдөлмөрийн хуульд заасны дагуу ажлын 8 цагаар үйл ажиллагаа явуулдаг.	Манай компани нь хөдөлмөрийн хуульд заасны дагуу ажлын 8 цагаар үйл ажиллагаа явуулдаг.

4.2 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

“Ерөнхийлөгчийн тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд төсөл хэрэгжих талбайд үе шаттайгаар 8258 ширхэг мод тарьсан. Орон нутгийн мод үржүүлгийн “Модны эх ургац” ХХК-аас 800 ширхэг 2-3 насны хайлаас төслийн талбай ойролцоо суулгасан.



Орон нутгийн “Тэрбум мод” хөтөрбөрийн нээлтийн үйл явцаас:



4.3 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Тус төслийн талбайд одоогоор түүх, соёлын өв илрээгүй. Тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах шаардлагатай.



4.4 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Энэхүү төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг тусгалаа.



Хүснэгт №. 2 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ Тоо хэмжээ	Хэргжүүлэх хувь	Тайлбар	Зураг
Цаг агаарын үзэгдэл, ажилчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан осол гарах	Цаг агаарын мэдээг байнга авч үйл ажиллагаатайгаа холбон ажиллах, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх гарын авлагатай болох	Үйл ажиллагааны явцад	100	Цаг агаарын мэдээг байнга авч үйл ажиллагаатайгаа холбон ажиллах, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх гарын авлага бий болгосон.	
	Ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулах, аюулгүй ажиллагааны талаарх мэдээллийг өгч байх, самбартай байх	Үйл ажиллагааны явцад	100	Ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулах, аюулгүй ажиллагааны талаарх мэдээллийг өгч байх, самбарыг төслийн талбайд байршуулсан	

“ПАТРИКЕЙН” ХХК

	Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл холбооны хэрэгсэлтэй болох	Үйл ажиллагааны явцад	100	Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл холбооны хэрэгсэлтэй болсон.	
	Болзошгүй аюул ослын үед ашиглах мөнгөн хуримтлал бүрдүүлэх	Үйл ажиллагааны явцад	100	Болзошгүй аюул ослын үед ашиглах мөнгөн хуримтлал бүрдүүлэх / ААН-ийн өөрийн мөнгөн хуримтлалд хадгална/	Болзошгүй аюул ослын үед ашиглах мөнгөн хуримтлал бүрдүүлэх / ААН-ийн өөрийн мөнгөн хуримтлалд хадгалж байна/
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх, байгалийн гамшиг	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах, Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших	Үйл ажиллагааны явцад	100	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах, Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж байгаа.	

“ПАТРИКЕЙН” ХХК

	<p>Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах</p>	<p>Үйл ажиллагааны явцад</p>	<p>100</p>	<p>Болзошгүй осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор галын хор, гал унтраах хэрэгсэлүүд болон богино долгионы холбооны хэрэгслээр ажилчдыг хангаж ажилласан.</p>	
	<p>Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөөтэй байх</p>	<p>Үйл ажиллагааны явцад</p>	<p>100</p>	<p>Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөө гаргаж батлуулан, ажиллаж байна.</p>	
	<p>Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сумын байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах</p>	<p>Үйл ажиллагааны явцад</p>	<p>100</p>	<p>Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулсан. Сумын байгаль орчны байцаагчтай байнгын холбоотой ажиллаж байна.</p>	<p>Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулсан. Сумын байгаль орчны байцаагчтай байнгын холбоотой ажиллаж байна.</p>

“ПАТРИКЕЙН” ХХК




Эрүүл мэнд	Ажилчдыг жилд 2 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Үйл ажиллагааны явцад	100	Бүх ажилчдыг үзлэгт хамруулан, Гранд мед эмнэлэгтэй гэрээ хийсэн.	Бүх ажилчдыг үзлэгт хамруулан, Гранд мед эмнэлэгтэй гэрээ хийсэн.
	Ковидын нөхцөлд цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг өргөн хүрээнд хамруулах ба давтамжийг нэмэгдүүлсэн хуваарь тогтоох (жишээлбэл, цэвэрлэгээ хийх ажлын цаг болон/эсвэл цэвэрлэгээ хийдэг ажилтны тоог нэмэгдүүлэх, бусад Ажилтныг өөрсдийн ажлын талбай, тоног төхөөрөмжийг тогтмол цэвэрлэж, ариутгах)	Үйл ажиллагааны явцад	100	Ажилтныг өөрсдийн ажлын талбай, тоног төхөөрөмжийг тогтмол цэвэрлэж, ариутгах өдөр тутамдаа хийж гүйцэтгэж байна.	Ажилтныг өөрсдийн ажлын талбай, тоног төхөөрөмжийг тогтмол цэвэрлэж, ариутгах өдөр тутамдаа хийж гүйцэтгэж байна.

4.5 Орчны болон барилгажилтын хог хаягдлын төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт №. 3 Орчны болон барилгажилтын хог хаягдлын төлөвлөгөөний биелэлт

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэрэгжүүлсэн хувь	Тайлбар	Зураг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйг ээс орчин бохирдох Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Орчны хог хаягдлыг орон нутагтай хамтран цэвэрлэгээ арчилгаа хийх	Үйл ажиллганы турш	100	Орчны хог хаягдлыг орон нутагтай хамтран цэвэрлэгээ арчилгаа усалгаа хийсэн.	
	Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах	Үйл ажиллагааны турш	100	Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулсан.	
	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Үйл ажиллагааны турш	100	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулсан.	

“ПАТРИКЕЙН” ХХК

	<p>Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, аль болох олон газарт байрлуулах</p>	<p>Үйл ажиллагааны турш</p>	<p>100</p>	<p>Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, аль болох олон газарт байрлуулсан.</p>	
	<p>Сүмбэр сумтай хог хаягдлыг төвлөрсөн хог хаягдлын цэгт тээвэрлэх гэрээ байгуулах</p>	<p>Үйл ажиллагааны турш</p>	<p>100</p>	<p>Говьсүмбэр аймгийн Хот тохижилт үйлчилгээний газартай 2021 оны 08-р сарын 01-ны өдөр Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх тэдгээрт хяналт тавих гэрээ хийсэн.</p>	
	<p>Хог хаягдлыг ангилан цуглуулах цэгийг хашаажуулах, тэмдэг тэмдэглэгээ тавих</p>	<p>Үйл ажиллагааны турш</p>	<p>100</p>	<p>Хог хаягдлыг ангилан цуглуулах цэгийг хашаажуулсан.</p>	

4.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт №. 4 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Арга хэмжээний цар хэмжээ Тоо хэмжээ	Хэрэгжүүлсэн хувь	Тайлбар	Зураг
Хөрсний бохирдол					
Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх Түлш, тосолгооны материал болон хог хаягдлаар хөрс бохирдох	Төслийн талбайд 2 цэг сонгох /ажилчдын байр, ачих буулгах талбай орчим/ Жил тутамд	100	Хөрсний шилжилгээг “Ланд овнер” хөрс судлалын лабораторит шинжлүүлсэн.	 <p>The image shows two laboratory reports from 'GREEN LAB LLC' (ХӨРС СУДЛАЛЫН ЛАБОРАТОРИЙ) and a photograph of a soil sampling site. The photo includes a white tag with the text: '2022.10.20 "ПАТРИКЕЙН" ХХК Төслийн нэр: Ачилт буулгалтын талбай Хөрсний дээж № 1'.</p>
Хүнд металлын агууламж		2 цэгт /ажилчдын байр, ачих буулгах талбай орчим/ Жил тутамд	100		
Усны хяналт шинжилгээ					



<p>Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ</p>	<p>Төслийн талбай орчим</p>	<p>Унд ахуйн усыг хангаж буй уснаас 2022 он</p>	<p>100</p>	<p>Ажилчдын унд ахуйн усыг төслийн талбайн ойр орших худгаас хангадаг бөгөөд ундны усыг лабораторид өгч шинжлүүлэхэд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй бай на.</p>	
---	-----------------------------	---	------------	---	--

Агаарын чанар, дуу чимээ


<p>Тоосжилт (PM₁₀, PSM, PM₂₅); Гадаад болон дотоод орчны дуу чимээ, доргио, чичиргээ; Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлтүүд (тоос, дуу чимээ, гэрэлтүүлэг, чийгшил болон физик бохирдлын түвшин); Бохирдлын цэгэн эх үүсвэр (O₂, SO₂, NO₂, CO)</p>	<p>Төслийн талбай болон орчны бүсэд</p>	<p>Жилд 2 удаа 2022 он</p>	<p>100</p>	<p>Агаарын шинжилгээг Цаг уур, орчны шинжилгээний газар байгаль орчин, хэмжил зүйн лаборатори хийлгэсэн.</p>	
--	---	----------------------------	------------	--	--

4.7 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт


Хүснэгт №. 5 Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэрэгжүүлсэн хувь	Тайлбар	Зураг
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх шинэчлэн засварлах	Төслийн хэмжээнд	100	Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд таримал модыг услах, арчлах, хамгаалах тухай ажилтан албан хаагчдад байнгын сануулж зөвлөж байна.	
2	Байгаль орчныг хамгаалах, осол аваар, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар жилд 2 удаа сургалт, судалгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	Төслийн хэмжээнд	100	ХАБ-ын сургалт зохион байгуулсан.	
3	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ-т хүргэн өгч байх	Төслийн хэмжээнд	100	БОАЖЯ-нд 11-р сарын 1 нээс өмнө хийсэн ажлын тайланг хүргүүлнэ	Еic.mn мэдээллийн санд шивсэн

“ПАТРИКЕЙН” ХХК

4	Байгаль хамгаалахад сум багийн холбогдох ажилтнуудын оролцоог идэвхижүүлэх, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-нд тусгах	Төслийн хэмжээнд	100	Байгаль хамгаалахад сум багийн холбогдох ажилтнуудын оролцоог идэвхижүүлэх, уулзалт зөвлөгөөг зохион байгуулсан	Байгаль хамгаалахад сум багийн холбогдох ажилтнуудын оролцоог идэвхижүүлэх, уулзалт зөвлөгөөг зохион байгуулсан
5	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө	Төслийн хэмжээнд	100	ХАБ-ын сургалт зохион байгуулсан.	
6	Бүх ажилчидыг жилд 1 удаа эмчийн үзлэгт хамруулж байх	Төслийн хэмжээнд	100	Бүх ажилчидыг жилд 1 удаа эмчийн үзлэгт хамруулсан.	Бүх ажилчидыг жилд 1 удаа эмчийн үзлэгт хамруулсан.

“ПАТРИКЕЙН” ХХК

7	Хөдөлмөр хамгаалал эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах сургалт зохион байгуулах, галын аюулгүй ажиллагааны талаар дүүргийн ГТТХХэлтэстэй хамтран галын аюулаас урьдчилан сэргийлэх үзүүлэх сургууль хийх	Төслийн хэмжээнд	100	Хөдөлмөр хамгаалал эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, ГТТХХэлтэсээс зохион байгуулсан үзүүлэх сургалтад ХАБ болон ажилчдын хамт хамрагдсан.	
8	ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулах	Төслийн хэмжээнд	100	ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулсан.	ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулсан.

“ПАТРИКЕЙН” ХХК

9	Ажилчдыг шаардлагатай хувцас, тусгай хамгаалах, амны хаалт, малгай зэргээр хангах	Төслийн хэмжээнд	100	Ажилчдыг шаардлагатай хувцас, тусгай хамгаалах, амны хаалт, малгай зэргээр хангасан.	 
11	Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлд зарцуулах зардал	Төслийн хэмжээнд	100	Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлд нийт 350.0 зарцуулсан.	


“ПАТРИКЕЙН” ХХК

12	Ковидын нөхцөлд ажилчдын дархлааг дэмжих бүтээгдэхүүнээр хангах	Төслийн хэмжээнд	100	Ковидын нөхцөлд ажилчдын дархлааг дэмжих бүтээгдэхүүнээр хангасан.	 
13	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны тайланг Теем смайл ХХК-аар хийлгэнэ	Төслийн хэмжээнд	100	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны тайланг 2020 онд “Экситос”ХХК-аар хийлгэсэн.	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны тайланг 2020 онд “Экситос”ХХК-аар хийлгэсэн.

4.8 Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт №. 6 Оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутгийн оршин суугч болон засаг захиргааны байгууллагад танилцуулж хэлэлцүүлнэ.	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	2022 оны 11-р сар	-	БО-ны мэргэжилтэн, үйлдвэрийн дарга	Сумын иргэдийн нийтийн хурлын танхим, төсөл хэрэгжүүлж буй газар
Говьсүмбэр аймгийн БОАЖГ-т танилцуулан санал авах		БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	2022 оны 12-р сар	-		
БОАЖЯ-ны ХБОБНГ-т	-	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	Ажлын 5 хоногт багтаан хүргүүлнэ			



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИХ ТӨМӨР АЧИХ БУУЛГАХ

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

№. 05/09

Улаанбаатар хот

2022 оны 05 дугаар сарын 09-ны өдөр

Нэг талаас “ПАТРИКЕЙН” ХХК-ийг/5512778/ (захиалагч байгууллага, иргэний нэр, хаяг) (цаашид “Захиалагч” гэх) түүний төлөөлж Менежер Э.Баатардалай (төлөөлсөн хүний нэр, албан тушаал), нөгөө талаас “ОЙ АН ТӨВ” ХХК-ийг (ажил гүйцэтгэгч байгууллага, иргэний нэр, хаяг) (цаашид “Ажил гүйцэтгэгч” гэх) түүнийг төлөөлж Менежер Ж.Отгонбаяр (төлөөлсөн хүний нэр, албан тушаал) нар Монгол Улсын Иргэний хуулийн 343 - 358 дугаар зүйлийг удирдлага болгон дараахь гэрээр харилцан тохиролцож байгуулав.

1. Нийтлэг заалт

1.1. Гүйцэтгэгч нь захиалагчийн даалгаврын дагуу түүний хөрөнгөөр 4 га уурхайн эдэлбэр газарт Чачаргануу суулгагч тарьж ургуулан тохиролцсон хугацаанд гүйцэтгэж, захиалагчид хүлээлгэн өгнө.

1.2. Захиалагч нь гүйцэтгэсэн ажлыг хүлээн авч, хөлсийг гэрээгээр тохиролцсон хэлбэр, хугацаанд төлнө.

2. Гэрээний хугацаа

2.1. Ажил гүйцэтгэх хугацааг хоёр тал харилцан тохиролцож тогтоох бөгөөд календарын тооллыг удирдлага болгоно.

2.2. Ажил гүйцэтгэх ерөнхий хугацаа: 6 сар

2.3. Ажил эхлэх хугацаа: 2022 оны 05 сарын 09

2.4. Ажил дуусах хугацаа: 2022 оны 05 сарын 23

3. Ажлын хөлс

3.1. Гэрээгээр гүйцэтгэх ажлын нийт хөлс 40.000.000 төгрөг байна.

ТАЛБАЙ БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

“ПАТРИКЕЙН” ХХК

9. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах журам

- 9.1. Ажилд гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж, талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 9.2. Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжинд заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож, гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

10. Талуудын хаяг

Захиалагч:

Хаяг:



Утас: 95959799

Гарын үсэг: Э.Баатардалай
(тамга, тэмдэг)

Ажил гүйцэтгэгч:

Хаяг: Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум
Баян Ханы 4-р баг Данигай Дамдины
гудамж 150 тоот



Утас: 96073300 99179101

Гарын үсэг: /Б.Жамсран/
(тамга, тэмдэг)



“GREEN LAB” LLC
ХӨРС СУДЛАЛЫН ЛАБОРАТОРИ



№ 22/4927

Монгол улс, Улаанбаатар, Шивхэн-6 дугуйр
6-р хороо, Цэц Кэвчинг байр 10 дүгээр/2 тоот
Утас/Факс: 77002020, 98077113
E-mail: landownermongolia@gmail.com

Дүж ирсэн огноо: 2022.10.26-28

Шинжилгээ хийлгэж буй байгуулагча, хувь хүн: “Патрикейн” ХХК

Холбоо барих дугаар: 86005082

Дүж авсан газар: Говьсүмбэр аймаг Сүмбэр сум, 2-р баг Аккалын 100 тоот “Патрикейн” ХХК Ачилт буулгалтын талбай

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн

№	Лаб №	Дэвжний нэр	Гүн см	рН	Давс, %	ЦДЦ	СО ₂ , %	Яллаг, %	Шингээгдсэн сууриал, мг-эс/100 гр			Шийм тэжээлийн элементүүд мг/100 гр		
									Са+Мг	Са	Мг	Р ₂ О ₅	К ₂ О	
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	
1	22/5833	Дэж-1	0-30	8.04	0.03	0.069	0.00	0.86	14.4	11.8	2.6	1.8	15	
2	22/5834	Дэж-2	0-30	8.36	0.04	0.072	0.00	0.76	13.0	10.2	2.8	1.2	13	

Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Лаб №	Дэвжний нэр	Гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм							
				1-0.25	0.25-0.075	0.075-0.025	0.025-0.0075	0.0075-0.0025	0.0025-0.00075	<0.00075	>0.075
1	22/5833	Дэж-1	0-30	38.8	43.3	4.3	4.6	3.8	5.2	13.6	
2	22/5834	Дэж-2	0-30	37.2	40.6	4.5	4.7	8.0	4.9	17.7	

Хөрсний хунд металл

№	Лаб №	Дэвжний нэр	Гүн, см	Хунд металл мг/кг						
				Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Cu /Зэс/	Zn /Цайр/	Cr /Хром/	
1	22/5833	Дэж-1	0-30	15.6	-	15.6	20.3	40.6	33.5	
2	22/5834	Дэж-2	0-30	15.0	-	21.4	24.8	66.1	37.5	
Шаврагчид хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээ				100.0	1.5	70.0	80.0	150.0	100.0	
Элсэлгэр хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээ				60.0	1.0	50.0	60.0	100.0	60.0	
Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт				/MNS 5850:2019/						

Жич: Шинжилгээний харуу нь зөвхөн тухайн нэгдэйн дэвжинд хамаарах ба хувилган олшруулахыг хориглоно.

Шинжилгээ хийсэн арга стандарт:
(MNS3310:1991, MNS 6824:2020 MNS ISO 11466:2007)

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:

Шинжээч:
Шинжээч:
Шинжээч:

Т.Гуралтуяа
С.Мэгмараш
М.Энхсала
Г.Гашимор /MS/

ХЯНАСАН:

Лабораторийн эрхлэгч

“ПАТРИКЕЙН” ХХК



Монгол Улс, Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг
Бүр хэрэг: Нэг Кооптат /булр 10-д/авчар102 нөхц
Утас/Факс: 77802020 /98007313
E-mail: landowner@mongoliaspatial.com

Дэвж ирсэн огноо: 2022.10.26-28
Шинжилгээ хийлгэж буй байгууллага, хувь хүн: "Патрикейн" ХХК
Холбоо барих дугаар: 86005082
Дэвж ирсэн газар: Говьсүмбэр аймаг Сүмбэр сум, 2-р баг Амгалан 100 тоот "Патрикейн" ХХК Авилт буулгалтын

"GREEN LAB" LLC
ХӨРС СУДЛАЛЫН ЛАБОРАТОРИ



№ 22/4928

Хөрсний эрүүл ахуй

№	Лаб №	Дэвжний нэр	Нангийн тоо MNS 63416.2012		Гэдсэний сахицгарын титр (E Coli) MNS 5367.2004		Амарробын (Cl.perfringens) MNS 6341.2012	
			Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдалын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдалын зэрэг	
1	22/5833	Дэвж-1	3.0*10 ⁴	0.1	Бага зэрэг Бохирдолтой	0.1<	Цэвэр	
2	22/5834	Дэвж-2	1.0*10 ⁴	1.0	Цэвэр	0.1<	Цэвэр	

Жагс: Шинжилгээний хариу нь зөвхөн тухайн үзлийн дэвжэнд хамаарах ба хувилган олшруулахыг хориглоно.

Шинжилгээ хийсэн арга стандарт:
(MNS 6341:2012, MNS 5367:2004, MNS 3297:2019)

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭГТЭСЭН: Шинжээч: _____
Шинжээч: _____
Шинжээч: _____

ХЯНАСАН: Лабораторийн эрхлэгч: _____



Г. Гэрэлтуяа
С. Мэгмардаш
М. Энхзаяа

Г.Гамчимсэг /MS of

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ
ХЭРЭГЖИХ ТӨМӨР
АЧИХ БУУЛГАХ

Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын
5-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт

НЭХЭМЖЛЭХ № 65


Нэхэмжлэгч: _____ Төлөгч: _____
Байгууллагын нэр: Эндриета Брани ХХК Байгууллагын нэр: _____
Хаяг: _____ Хаяг: _____

Утас: Факс: 99257478
Э шуудан _____ Гэрээний № 65
Банкны нэр: Талбай Банк
Банкны дансны дугаар: 2705007741 Нэхэмжилсэн огноо: 2024.11.2
Регистрийн №: _____ Төлбөр хийх хугацаа _____

№	Гүйлгээний утга	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
	<u>Рв.ийн ажлын хувьцаа</u>	<u>27</u>	<u>180,000</u>	<u>4,860,000</u>
			Дүн	<u>4,118,181</u>
			НӨАТ	<u>441,818</u>
			Нийт дүн	<u>4,860,000</u>

Мөнгөний дүн: Мөнгөний сая найман зуун
таван мянган тусгай төгрөг болно.

Дарга: _____
Хүлээн авсан: _____
Нягтлан бодогч: _____



УЛААНБААТАР УОТ

ТАЛБАЙ БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

“ПАТРИКЕЙН” ХХК

Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт

НЭХЭМЖЛЭХ №

Нэхэмжлэгч: Баттөвшөр Төлөгч: Патрикейн ХХК
 Байгууллагын нэр: Наурсан Байгууллагын нэр: _____
 Хаяг: Сэлэнгэ бүс Хаяг: _____
5 ргн Урлин
 Утас: Факс: 99179101
 Э шуудан _____ Гэрээний № _____
 Банкны нэр Аааа банк
 Банкны дансны дугаар 5692229311 Нэхэмжилсэн огноо 2022.05.16
 Регистрийн №: _____ Төлбөр хийх хугацаа 2022.05.20

№	Гүйлгээний утга	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
	Зурвас найсаас	3 га.	11.250.000	33.750.000
	Тосол /чрс, авт	кк	6.250.000	6.250.000
	Няас 300м			
	Найсаас	8000 м²		
	Нярс	30 м		
	Чумас	95 м		
	Авс	160 м		
Нийт дүн				40.000.000

Мөнгөний дүн Дотом сав хэргэс болно.
 (үсгээр)
 Дарга _____ /
 Хүлээн авсан _____ /
 Нягтлан бодогч С.Ганболд /

СЭЛЭНГЭ АЙМАГ
ОЙ АН ТӨВ
ХХК
(Тамга)
Утас: 99179101

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИХ ТӨМӨР АЧИХ БУУЛГАХ 36

БОЛОВСРУУЛСАН ХАБЗА АЖИЛТАН: ... /С.Ганболд/ ГОВЬСҮМБЭР АЙМАГ 2022 ОН

ХЯНАСАН:
 ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ОНШГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ТАМШГААС ХАМГААЛДАХ
 ТӨЛӨВЛӨГӨЛТ БЭЛЭН БАЙДАЛ ХАРИУЛСАН АХИАХ МЭРГЭЖИЙГЭН, ТАМШГААС ХАМГААЛДАХ
 УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦАМТ Ч.ХОШЛУУЧ /С.Ганболд/ БОЛЗИНСАЙХАН

ПАТРИКЕЙН ХХК-ны Говьсүмбэр аймаг дахь төмөр замын ачит, буулгалтын салбар

ТАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Баттөвшөр /С.Ганболд/

ОБЕГ -ын даргын 2022 оны ... дүгээр сарын ... ны өдрийн ... дүгээр тушаалын хавсралт

ТАЛБАЙ БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН